МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 26 өдөр Дугаар А/180 Улаанбаатар хот

# Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 214 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүй болон бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Стратеги бодлого, төлөвлөлтийн газар /Э.Батболд/, Хүнд үйлдвэр, газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Анхбаяр/ -т тус тус даалгасугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох журмын дагуу Засгийн газарт танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Ганхүү/-т үүрэг болгосугай.

САЙД Д.СУМЪЯАБАЗАР

08 1096

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2019 оны 08 дугаар сарын 26-ний
өдрийн А/180 дугаар тушаалын хавсралт

# ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Хөтөлбөрийн зорилго:** Монгол Улсын эдийн засгийн суурь бүтцийг бүрдүүлэх зорилгоор дэд бүтцийн хөгжил, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан металлурги, машин байгууламж, газрын тос, нүүрс боловсруулах болон химийн үйлдвэрийг байгуулж хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн нутагшуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, улмаар хүнд үйлдвэрийн салбараас эдийн засагт оруулах үр өгөөжийг дээшлүүлэхэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

| Зорилго | | | Хөтөлбөрийн зорилго | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт) | | | Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан үр нөлөөг бичнэ. Түүнчлэн хэрэгжилтийн үр дүнг үнэлэхэд ашиглах үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг бичнэ. | | | | |
| 1. Үйл ажиллагааны чиглэл | | | Бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл | | | | |
| № | Д/д | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа |
| **Зорилт 1: Хүнд үйлдвэрийн хууль эрх зүй, хөрөнгө оруулалт болон татварын таатай, тогтвортой орчинг бий болгох;** | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 1.1. хүнд аж үйлдвэрийн хууль эрх зүй, хөрөнгө оруулалт болон татварын таатай, тогтвортой орчныг бүрдүүлсэн байна: | | | | | | | |
| 1 | 1.1.1. | "Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хууль"-ийн төслийг боловсруулах; | Хууль эрх зүйн акт гарсан байна. | Батлуулсан хуулийн төслийн тоо | УУХҮЯ | АМГТГ | 2020-2021 |
| 2 | 1.1.2. | Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах; | Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулсан байна. | Хуульд нэмэлтээр орсон өөрчлөлтийн тоо | УУХҮЯ, ХХААХҮЯ | АМГТГ | 2020-2023 |
| 3 | 1.1.3. | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах; | Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлуулсан байна. | Хуульд нэмэлтээр орсон өөрчлөлтийн тоо | УУХҮЯ | ХХААХҮЯ | 2019-2020 |
| 4 | 1.1.4. | Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах; | Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн байна. | Сангийн яаманд хүргүүлсэн саналын тоо | СЯ | УУХҮЯ, ҮХГ | 2020 |
| 5 | 1.1.5. | Хүнд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортлоход Гааль, НӨАТ-аас чөлөөлөх эрхзүйн орчныг бүрдүүлэх; | Хуулийн төсөл боловсруулж Сангийн яаманд хүргүүлнэ. | Боловсруулсан хуулийн төслийн тоо | УУХҮЯ, СЯ | АМГТГ | 2020-2022 |
| 6 | 1.1.6. | Хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгж, байгууллагуудад эргэлтийн хөрөнгийн бага хүүтэй зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэх; | Хөрөнгө оруулагчидтай харилцаа холбоо тогтоосон байна. | Хөрөнгө оруулагчдын тоо<br>Хөрөнгө оруулалтын хэмжээ | УУХҮЯ | АМГТГ, Олон улсын байгууллагууд | 2020-2022 |
| 7 | 1.1.7. | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, Газрын тос боловсруулах үйлдвэр, Нүүрс гүн боловсруулах үйлдвэр болон Хар төмөрлөгийн цогцолборыг барьж байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг татахад төр хувь эзэмших, баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх; | Томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор төр хувь эзэмших болон баталгаа гаргах арга хэмжээ авсан байна. | Дэмжлэг үзүүлсэн төслийн тоо | УУХҮЯ | АМГТГ | 2019-2023 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 1.1.8. | Хүнд үйлдвэрийн салбарыг бүтээгдэхүүний зах зээл, эрэлт хэрэгцээ, түүхий эдийн нөөцтэй уялдуулж хөгжүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийх, энэ чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах; | Олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллах замаар судалгаанууд хийгдсэн байна. | Хийгдсэн судалгааны ажлын тоо | УУХҮЯ | ҮХГ, ЖАЙКА, СЕСМИМ, МЕРИТ, АМЕП | 2019-2020 |
| 9 | 1.1.9. | Гадаад улс орнуудтай байгуулсан худалдаа, эдийн засгийн хэлэлцээрүүдэд хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын худалдаанд импортлогч орноос тавьж байгаа тарифын болон тарифын бус хориг саадыг багасгах; | Засгийн газар хоорондын хэлэлцээрт оролцож, санал тавьж хэлэлцүүлсэн байна. | Боловсруулан хэлэлцүүлсэн саналын тоо | ГХЯ<br>УУХҮЯ | Монгол Улсад суугаа БНХАУ, ОХУ-ын элчин сайдын яам | 2019-2021 |
| 10 | 1.1.10. | Импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр дотоодын үйлдвэрлэлийн худалдан авалтыг бодлогоор дэмжих, дотоодын зах зээлийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | ЗГ-ын 2015 оны 336 дугаар тогтоолд оруулах өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж, Засгийн газарт танилцуулна. | Боловсруулж, танилцуулсан саналын тоо | ХХААХҮЯ,<br>УУХҮЯ | Холбогдох яамд | 2019-2020 |
| | | | Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай санал боловсруулж, Засгийн газарт танилцуулна. | Боловсруулж, танилцуулсан саналын тоо | ХХААХҮЯ,<br>УУХҮЯ | Холбогдох яамд | 2020-2021 |
| 11 | 1.1.11. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн хөгжлийг дэмжих, чадавхыг дээшлүүлэх чиглэлээр олон улсын хөгжлийн байгууллагуудын хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийн арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлэх, хамтран ажиллах; | Санамж бичиг, гэрээ хэлэлцээр байгуулсан байна. | Байгуулсан санамж бичиг, гэрээ хэлэлцээрийн тоо | УУХҮЯ, ҮХГ | Дэлхийн банк, АХБ, ЖАЙКА, КОЙКА, СЕСМИМ, МЕРИТ | 2019-2023 |
| 12 | 1.1.12. | Хүнд үйлдвэрийн техник, технологийн аудитын механизмыг бий болгох. | Журам болон аргачлал боловсруулагдсан байна. | Боловсруулсан журам, аргачлалын тоо | УУХҮЯ,<br>ХХААХҮЯ | БСШУСЯ, МХЕГ, ГЕГ | 2020-2021 |
| **Зорилт-2. Гадаад улс орнуудтай хүнд үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллах;** | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 2.1. Өмнөд бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан станцыг Тавантолгойн ордыг түшиглэн байгуулна. | | | | | | | |
| 13 | 2.1.1. | Өмнөд бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээний судалгааг хийж нарийвчилсан тооцооллыг гаргах; | Эрчим хүчний хэрэгцээний судалгаа хийгдсэн байна. | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо | УУХҮЯ | ЭХЯ, Төслийн нэгж | 2019-2020 |
| 14 | 2.1.2. | Тавантолгойн ордыг түшиглэн цахилгаан станц байгуулах төслийг дэмжиж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах. | -Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан байна.<br>-Төслийг дэмжихээр санал боловсруулсан байна | -Харилцаа тогтоосон төрийн болон төрийн бус байгууллагуудын тоо<br>-Төслийг дэмжихээр боловсруулсан саналын тоо | ЭХЯ, УУХҮЯ | АМГТГ, холбогдох бусад байгууллагууд | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 2.2. Хэрлэн голд урсацын тохируулга хийж, түүнийг алсын зайд дамжуулан ашиглах болон газрын доорх усыг гадаргын устай хосолмол байдлаар ашиглах боломж нөхцөлийн талаар судалгаа хийж, боломжтой газруудад зураг төсөл зохиох, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. | | | | | | | |
| 15 | 2.2.1. | Өмнөд бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн төслүүдийн усны хэрэгцээний судалгааг хийж нарийвчилсан тооцооллыг гаргах; | Усны хэрэгцээний судалгаа хийгдсэн байна. | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо | БОАЖЯ, УУХҮЯ | Төслийн нэгж, АМГТГ | 2019-2020 |
| 16 | 2.2.2. | Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийж, түүнийг алсын зайд дамжуулан ашиглах судалгаа хийх; | Судалгаа хийгдсэн байна. | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо | БОАЖЯ, УУХҮЯ | Төслийн нэгж, АМГТГ | 2019-2020 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | 2.2.3. | Газрын доорх усыг гадаргын устай хосолмол байдлаар ашиглах боломж нөхцөлийн талаар судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Судалгаа хийгдсэн байна. Судалгааны дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо Холбогдох байгууллагад хүргүүлсэн зөвлөмжийн тоо | БОАЖЯ, УУХҮЯ | Төслийн нэгж, АМГТГ | 2019-2020 |
| Үйл ажиллагааны чиглэл 2.3. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян, Сайншанд-Хөөт, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр зам болон говийн бүсэд хэрэгжүүлэх авто замын төслүүдийг барьж байгуулна; | | | | | | | |
| 18 | 2.3.1. | Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян, Сайншанд-Хөөт, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд уг төмөр замаар дамжин өнгөрөх уул уурхай, хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний ачаа эргэлтийн тооцооллыг гаргах; | Судалгаа хийгдсэн байна. | Хийгдсэн судалгааны ажлын тоо. | УУХҮЯ, ЗТХЯ | АМГТГ | 2019-2020 |
| 19 | 2.3.2. | Говийн бүсийн автозам, төмөр замын төслүүдийг дэмжиж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах. | Холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна. Төслийг дэмжих санал боловсруулсан байна. | Хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагуудын тоо Төслийг дэмжихээр боловсруулсан саналын тоо | УУХҮЯ, ЭХЯ | БХБЯ, АМГТГ, холбогдох бусад байгууллагууд | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 2.4. Тавантолгой болон Зүүн бүсийн нүүрсний ордыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн паркийг дэд бүтцийн хамт цогцоор нь байгуулж хөгжүүлнэ; | | | | | | | |
| 20 | 2.4.1. | Тавантолгойн ордыг түшиглэн нүүрс баяжуулах, нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлыг судлах судалгааны нэгжийг байгуулж ажиллуулах; | “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дэргэд судалгааны нэгж байгуулагдаж судалгаа хийсэн байна. | Боловсруулсан судалгааны тоо | “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ТУЗ | - | 2019-2020 |
| 21 | 2.4.2. | Судалгаанд үндэслэн Тавантолгойн ордыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлаар санал дүгнэлт боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх. | Санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулна. | Засгийн газрын хуралдааны шийдвэр | УУХҮЯ | “Эрдэнэс-Тавантолгой” ХК | 2020 |
| 22 | 2.4.3. | Дорноговь аймагт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийг түшиглэн газрын тос боловсруулах-кокс-хими-металлургийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлыг судлах судалгааны нэгжийг байгуулж ажиллуулах; | “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн дэргэд судалгааны нэгж байгуулагдаж судалгаа хийсэн байна. | Боловсруулсан судалгааны тоо | “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн ТУЗ | - | 2019-2020 |
| 23 | 2.4.4 | Судалгаанд үндэслэн Газрын тос боловсруулах үйлдвэрийг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах; | Санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулна. | Засгийн газрын хуралдааны шийдвэр | УУХҮЯ | “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК | 2020 |
| **Зорилт-3. Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг байгуулах бэлтгэлийг хангах, алт цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах;** | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 3.1. Эрдэнэт болон Оюу толгой ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр бай улах бэлтгэлийг хангаж, зэс экспортлогч орон болох үндэс суурийг тавих; | | | | | | | |
| 25 | 3.1.1. | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, БОННҮ-г боловсруулах ажлыг зохион байгуулах; | ТЭЗҮ боловсруулсан байна. БОННҮ-ний судалгаа боловсруулсан байна. | Боловсруулсан ТЭЗҮ болон БОННҮ-ний судалгаа | УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, Төслийн нэгж | Холбогдох бусад байгууллагууд | 2019-2020 |
| 26 | 3.1.2. | Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах арга хэмжээ авах; | Сонгон шалгаруулалтаар хөрөнгө оруулагчийг сонгосон байна. | Сонгон шалгаруулсан хөрөнгө оруулагчдын тоо | УУХҮЯ, ҮХГ, Төслийн нэгж | Төслийн нэгж | 2019-2020 |
| 27 | 3.1.3. | Үйлдвэрийн барилга байгууламжийг барьж байгуулах; | Үйлдвэрийн барилга байгууламж барьсан байна. | Улсын комиссын дүгнэлт | УУХҮЯ, БХБЯ, Төслийн нэгж | Холбогдох бусад байгууллагуу | 2020-2023 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | д МХЕГ | |
| Үйл ажиллагааны чиглэл 3.2. Хүхэрт хийг боловсруулж хүхэр гарган авах технологи болон нүүрсний давхаргын байгалийн хийг ашиглах боломжийг судлах; | | | | | | | |
| 28 | 3.2.1. | Хүхэрт хийг боловсруулж хүхэр гарган авах технологийн талаар судалгаа хийх ажлыг зохион байгуулах; | Судалгаа хийгдсэн байна. | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо | УУХҮЯ | АМГТГ, ШУТИС, мэргэжлийн холбоод | 2010-2021 |
| 29 | 3.2.2. | Нүүрсний давхаргын байгалийн хийг ашиглах боломжийг судлах. | Судалгаа хийгдсэн байна. | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо | УУХҮЯ | АМГТГ, ШУТИС, мэргэжлийн холбоод | 2020-2021 |
| 3.3. Хүхрийн хүчлийг фосфоритын баяжмалд уусгаж, фосфорын бордоо гаргаж авах судалгаа хийх, туршилт явуулах; | | | | | | | |
| 30 | 3.3.1. | Өмнө хийгдэж байсан судалгаануудад шинжилгээ хийж, өнөөгийн нөхцөл байдлын талаар судалгаа хийх; | Өмнөх судалгааны үр дүнг ашиглан судалгаа хийгдсэн байна | Хийгдсэн судалгааны тоо | УУХҮЯ | АМГТГ, ШУТИС, мэргэжлийн холбоод | 2020-2021 |
| Үйл ажиллагааны чиглэл 3.4. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс гарах хүхэрт хий болон бусад дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг байгуулах, байгаль орчны сөрөг нөлөөг багасгах, техник технологийн оновчтой шийдлийг сонгож, хэрэгжүүлэх; | | | | | | | |
| 31 | 3.4.1. | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрээс гарах хүхэрт хий болон бусад дайвар бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх; | Үйлдвэр байгуулахыг дэмжсэн санал боловсруулсан байна. | Боловсруулсан саналын тоо | УУХҮЯ,ҮХГ, Төслийн нэгж | АМГТГ | 2022-2023 |
| 32 | 3.4.2. | Хүхэрт хий боловсруулахад байгаль орчны сөрөг нөлөөг багасгах техник технологийн оновчтой шийдлийн талаар судалж боломжит хувилбарыг сонгох, хэрэгжүүлэх. | Судалгаа хийгдсэн байна Сонгосон хувилбарыг хэрэгжүүлсэн байна | Оновчтой технологийн талаар хийгдсэн судалгааны ажлын тоо | УУХҮЯ, Төслийн нэгж | АМГТГ, ШУТИС, мэргэжлийн холбоод | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 3.5. Хүхрийн хүчлийг тээвэрлэх, экспортын зах зээлд хүргэх тээвэр-ложистикийн сүлжээ байгуулах; | | | | | | | |
| 33 | 3.5.1. | Хүхрийн хүчлийн зах зээл, тээвэр-логистикийн талаар судлах; | Судалгаа хийгдсэн байна. | Хийгдсэн судалгааны ажлын тоо | УУХҮЯ, Төслийн нэгж | АМГТГ, ШУТИС, мэргэжлийн холбоод | 2019-2023 |
| 34 | 3.5.2. | Хүхрийн хүчлээс фосфоритын бордоо болон бусад бүтээгдэхүүн гарган авах боломжийн судалгааг боловсруулах. | Судалгаа хийгдсэн байна. | .Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны ажил | УУХҮЯ, Төслийн нэгж | АМГТГ, ШУТИС, мэргэжлийн холбоод | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 3.6. Катодын зэс үйлдвэрлэх шинэ үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах замаар цэвэр зэсийн үйлдвэрлэлийг тогтвортой нэмэгдүүлэх; | | | | | | | |
| 35 | 3.6.1 | Катодын зэсийн шинэ хүчин чадлыг ашиглалтад оруулахыг дэмжих; | Шинэ хүчин чадлыг дэмжих санал боловсруулсан байна. | Боловсруулсан саналын тоо | УУХҮЯ | АМГТГ | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 3.7. Катодын зэсээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, дотоодын болон гадаадын зах зээлд борлуулах; | | | | | | | |
| 36 | 3.7.1. | Зэс утасны үйлдвэрлэлийг дэмжиж, гадаад, дотоод зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлэх; | Зэс утасны үйлдвэр байгуулах, борлуулалтыг дэмжих санал боловсруулсан байна. | Боловсруулсан саналын тоо | УУХҮЯ | АМГТГ | 2019-2023 |
| 37 | 3.7.2. | Катодын зэсээр шинэ төрлийн бүтээгдэхүүн | Шинэ төрлийн бүтээгдэхүүн | Шинэ төрлийн бүтээгдэхүүний тоо | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлдвэрлэхийг дэмжих. | үйлдвэрлэсэн байна. | | УУХҮЯ | АМГТГ | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 3.8. Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх; | | | | | | | |
| 38 | 3.8.1. | Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг зохион байгуулах; | ТЭЗҮ боловсруулсан байна. БОННҮ-ний судалгаа боловсруулсан байна. | Ажлын даалгаврын дагуу хийгдсэн ТЭЗҮ БОННҮ-ний судалгаа | УУХҮЯ, Монгол банк, Эрдэнэс алт ресурс ХХК | Хувийн хэвшил | 2019-2020 |
| 39 | 3.8.2. | Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг барьж байгуулахыг бодлогоор дэмжих; | Барилга, байгууламж баригдсан байна. | Улсын комиссын дүгнэлт | УУХҮЯ, Монгол банк, Эрдэнэс алт ресурс ХХК | Хувийн хэвшил МХЕГ | 2021-2022 |
| 40 | 3.8.3. | Цэвэршүүлсэн алт, мөнгө болон бусад үнэт металлаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийн талаар судалгаа хийх | Судалгаа хийгдсэн байна. | Судалгаа хийгдсэн байна. | УУХҮЯ | “Эрдэнэс алт ресурс” ХХК | 2022-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 3.9. Молибденийн баяжмал боловсруулах үйлдвэр, хүхэрт натрийн үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүдийн үйл ажиллагаа сэргээн хөгжүүлэх; | | | | | | | |
| 41 | 3.9.1. | Үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон Молибденийн баяжмал боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, санал боловсруулах; | Санал боловсруулсан байна. | Боловсруулж танилцуулсан саналын тоо | УУХҮЯ | Холбогдох байгууллагууд | 2020 |
| 42 | 3.9.2. | Төв аймгийн Цээл суманд орших үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон Хүхэрт натрийн үйлдвэрийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, санал боловсруулах; | Санал боловсруулсан байна. | Боловсруулж танилцуулсан саналын тоо | УУХҮЯ | Холбогдох байгууллагууд | 2020 |
| Үйл ажиллагааны чиглэл 3.10. Зэсийн баяжмал боловсруулах болон алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулахад төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх; | | | | | | | |
| 43 | 3.10.1. | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барьж байгуулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих; | Хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэн байна. | Төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тоо | УУХҮЯ, Төслийн нэгж | Хувийн хэвшил | 2020-2023 |
| 44 | 3.10.2. | Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих. | Хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэн байна | | УУХҮЯ, Монгол банк, Эрдэнэс алт ресурс ХХК | Хувийн хэвшил | 2020-2023 |
| **Зорилт 4. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дагалдах үйлдвэрүүдийн хамт хөгжүүлэх;** | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 4.1. Ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах зорилгоор үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төмрийн хүдрийн боловсруулалтын түвшинг дээшлүүлэх замаар анхдагч хүдрийн экспортын хэмжээг үе шаттайгаар бууруулах; | | | | | | | |
| 45 | 4.1.1. | Говийн бүсэд 200.0 мян.тн/жил хүчин чадалтай ширэмний үйлдвэр, 50.0 мян.тн/жил хүчин чадалтай гангийн үйлдвэр барихад дэмжлэг үзүүлэх; | Ширэм ба гангийн үйлдвэр байгуулсан байна. | Улсын комиссын дүгнэлт, Бүтээгдэхүүний тоо хэмжээ | УУХҮЯ, хувийн хэвшил | МХЕГ | 2019-2020 |
| 46 | 4.1.2. | Төмрийн хүдрийн баяжмалын экспортын хэмжээг үе шаттайгаар бууруулах санал боловсруулах; | Баяжмалын экспортыг бууруулах төлөвлөгөө боловсруулсан байна. | Баяжмалын экспорт буурсан хувь хэмжээ | УУХҮЯ | Холбогдох бусад байгууллагууд | 2019-2022 |
| 47 | 4.1.3. | Төв болон говийн бүсэд жилдээ 10,0-15,0 мян.тн феррохайлш үйлдвэрлэх үйлдвэрийг байгуулахыг дэмжих; | Феррохайлшийн үйлдвэр байгуулсан байна. | Улсын комиссын дүгнэлт Дотоодын хэрэгцээг бүрэн хангана. | УУХҮЯ | Хувийн хэвшил МХЕГ | 2020-2022 |
| 48 | 4.1.4. | Өмнөговь, Говь-Алтай аймаг дахь ордын нөөцийг ашиглан галд тэсвэртэй материалын үйлдвэрийг байгуулах. | Галд тэсвэртэй материал үйлдвэр-1 Хром магнезит үйлдвэр-1 байгуулсан байна. | Улсын комиссын дүгнэлт Дотоодын хэрэгцээг хангана. | УУХҮЯ | БХБЯ, Хувийн хэвшил МХЕГ | 2020-2022 |
| Үйл ажиллагааны чиглэл 4.2. Төмрийн хүдрийг боловсруулах болон гангийн үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, техник технологийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авах; | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 49 | 4.2.1. | Гангийн үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах; | Гангийн үйлдвэрийн хүчин чадал, ашиглалтыг сайжруулах санал боловсруулсан байна. | Хүчин чадал, ашиглалт сайжруулах чиглэлээр боловсруулсан саналын тоо | УУХҮЯ | АМГТГ, ШУТИС, мэргэжлийн холбоод | 2019-2021 |
| 50 | 4.2.2. | Гангийн үйлдвэрүүдийн техник, технологийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр технологийн түвшний үнэлгээ хийх журам аргачлал боловсруулж мөрдүүлэх. | Журам, аргачлал боловсруулсан байна. | Боловсруулсан журам, аргачлалын тоо | УУХҮЯ | БХБЯ, АМГТГ, ШУТИС, мэргэжлийн холбоод | 2019-2021 |
| Үйл ажиллагааны чиглэл 4.3. Ган туйван, ган бөмбөлөг, ган утас зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах; | | | | | | | |
| 51 | 4.3.1. | Ган бөмбөлөгийн үйлдвэрүүдийн хүчин чадал ашиглалтыг сайжруулах; | Ган бөмбөлөгийн үйлдвэрүүдийн хүчин чадал, ашиглалтыг сайжруулах санал боловсруулсан байна. | Хүчин чадал, ашиглалт сайжруулахад чиглэлээр боловсруулсан саналын тоо | УУХҮЯ, АМГТГ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| 52 | 4.3.2. | Ган туйвангийн үйлдвэрүүдийн хүчин чадал ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах. | Ган туйвангийн үйлдвэрүүдийн хүчин чадал, ашиглалтыг сайжруулах санал боловсруулсан байна. | Хүчин чадал, ашиглалтыг сайжруулах чиглэлээр боловсруулсан саналын тоо | УУХҮЯ, БХБЯ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 4.4. Орхон болон Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах; | | | | | | | |
| 53 | 4.4.1. | Дархан-Сэлэнгийн бүсэд 600.0 мян.тн/жил хүчин чадалтай шууд ангижруулсан төмөр , 471.0 мян.тн хүчин чадалтай ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр барихад дэмжлэг үзүүлэх; | Ангижруулсан төмрийн үйлдвэр-1, гангийн үйлдвэр-1 баригдсан байна. | Улсын комиссын дүгнэлт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | УУХҮЯ | ҮХГ, Хувийн хэвшил МХЕГ | 2019-2023 |
| 54 | 4.2..2. | Орхон аймагт 100.0 мян.тн/жил хүчин чадалтай ширэмний үйлдвэр, 200.0 мян.тн/жил ган бүтээгдэхүүний үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх. | Ширэмний үйлдвэр-2, гангийн үйлдвэр-1 баригдаж ашиглалтад орсон байна. | Улсын комиссын дүгнэлт, Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | УУХҮЯ | Хувийн хэвшил МХЕГ | 2019-2021 |
| Үйл ажиллагааны чиглэл 4.5. Төр-хувийн хэвшлийн хамтарсан кокс, төмөрлөгийн үйлдвэрийн цогцолборыг байгуулахад дэмжлэг үзүүлэх; | | | | | | | |
| 55 | 4.5.1. | Говийн бүсэд 300.0 мян.тн/жил ган төмөр бүтээгдэхүүн, 500.0 мян.тн/жил металлургийн кокс үйлдвэрлэх хүчин чадал бүхий кокс, төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийг барьж байгуулахыг дэмжих; | Коксын үйлдвэр-1, гангийн үйлдвэр-1 баригдаж ашиглалтад орсон байх | Улсын комиссын дүгнэлт, Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ | УУХҮЯ | БХБЯ, Хувийн хэвшил МХЕГ | 2019-2023 |
| **Зорилт 5. Нүүрс гүн боловсруулах болон химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;** | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 5.1. Гадаад зах зээлийн импортын хэрэгцээ, монгол орны дэд бүтцийн дамжин өнгөрүүлэх чадвар, хөрөнгө оруулалтын өгөөж зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан нүүрсний салбарын үйлдвэрлэл, экспортын хэмжээг эрс нэмэгдүүлж, бүс нутгийн нүүрсний томоохон экспортлогч орон болох нөхцөлийг бүрдүүлэх; | | | | | | | |
| 56 | 5.1.1. | Нүүрсний гадаад зах зээлийн импортын хэрэгцээ, дэд бүтцийн дамжин өнгөрөх чадварыг нэмэгдүүлэх, зах зээлийн эрсдэлийн талаар судалгаа хийх; | Судалгаа хийгдсэн байна. | Судалгааны тоо | УУХҮЯ | АМГТГ, "Эрдэнэс таван толгой" ХК | 2020-2021 |
| 57 | 5.1.2. | Төвийн бүсэд жилд 300.0 мян.тн кокс, 20 МВт эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийг дэмжих; | Барилгын ажил эхэлсэн байна. | Улсын комиссын дүгнэлт | УУХҮЯ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 5.2. Таван толгойн нүүрсний олборлолт, боловсруулалтыг экспортод чиглэсэн иж бүрэн чиглэлээр хөгжүүлэх; | | | | | | | |
| 58 | 5.2.1. | Боловсруулалтын түвшинг ахиулж, баяжуулах болон гүн боловсруулах үйлдвэр барих нөхцөлийг бүрдүүлэх; | Нүүрсийг хагас болон гүн боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, БОННҮ хийгдсэн байна. | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо | УУХҮЯ, "Эрдэнэс таван толгой" ХК, "Эрдэнэс | Хувийн хэвшил | 2019-2023 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | монгол" ХХК | | |
| Үйл ажиллагааны чиглэл 5.3. Говийн болон Зүүн бүсийн ордуудыг түшиглэн кокс химийн үйлдвэрийг зах зээлийн эрэлт хэрэгцээ, түүхий эдийн нөөц, шинж чанарт тулгуурлан хөгжүүлэх арга хэмжээг авах; | | | | | | | |
| 59 | 5.3.1. | Өмнөговь аймгийн Баян-Овоо суманд баригдсан кокс химийн үйлдвэрийн хүчин чадлыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх; | Үйлдвэрийн хүчин чадал нэмэгдсэн байна. | Үйлдвэрийн хүчин чадал өсөлтийн хувь хэмжээ | УУХҮЯ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 5.4. Таван толгойн ордыг түшиглэн нүүрс-химийн үйлдвэрийг барьж байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх; | | | | | | | |
| 60 | 5.4.1. | Нүүрс-химийн үйлдвэрийг барьж байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх. | ТЭЗҮ, БОННҮ хийсэн байх ба Хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулсан байна. | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо Хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээний тоо | УУХҮЯ, АМГТГ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 5.5. Нялга-Чойрын дүүргийн нүүрсний ордуудыг түшиглэн нүүрс хийжүүлэх үйлдвэрийг барьж байгуулах; | | | | | | | |
| 61 | 5.5.1. | Жилд 725 сая м$^3$ байгалийн хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг барьж байгуулах; | Барилгын ажил эхэлсэн байх Хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулсан байна. | Улсын комиссын дүгнэлт, Хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээний тоо | УУХҮЯ, АМГТГ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| 62 | 5.5.2. | Нүүрнээс химийн болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж, технологи, зах зээлийн эрсдэлийн талаар судалгаа хийх, үйлдвэрийг барьж байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлэх. | Судалгаа, ТЭЗҮ, БОННҮ хийсэн байх . | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо | УУХҮЯ | Холбогдох бусад байгууллагууд | 2020-2023 |
| **Зорилт 6. Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулж, хөгжүүлэх;** | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 6.1. Дорноговь аймагт газрын тос боловсруулж, авто бензин, дизель түлш зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг барьж байгуулах; | | | | | | | |
| 63 | 6.1.1 | ЕВРО-4, 5 стандартын шаардлага хангасан автобензин, дизель түлш, онгоцны түлш, шингэрүүлсэн шатдаг хий, мазут болон бусад дагалдах бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг барьж байгуулах; | Үйлдвэр баригдсан байна. Бүтээгдэхүүн гарсан байна. | Барилгын комиссын дүгнэлт, Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо | УУХҮЯ, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК | Холбогдох бусад байгууллага МХЕГ | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 6.2. Газрын тосоор тогтвортой хангах, нөөц нэмэгдүүлэхэд чиглэсэн ашиглалтын үеийн хайгуулын ажлыг эрчимжүүлэх; | | | | | | | |
| 64 | 6.2.1. | Газрын тосны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох судалгаа хийх ажлыг зохион байгуулах; | Судалгаа хийгдсэн байна. | Баримт нотолгоо, хэрэглээнд суурилсан судалгааны тоо | УУХҮЯ | Холбогдох бусад байгууллагууд | 2019-2022 |
| Үйл ажиллагааны чиглэл 6.3. Газрын тосны бүтээгдэхүүний бага оврын үйлдвэрүүдийг бодлогоор дэмжих; | | | | | | | |
| 65 | 6.3.1. | Газрын тос, занар болон нүүрнээс газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг дэмжих; | Хууль эрхзүйн орчин бүрдсэн байна. | Хууль эрхзүйн орчинд өөрчлөлт оруулахаар боловсруулсан саналын тоо | УУХҮЯ | Холбогдох бусад байгууллагууд | 2019-2020 |
| **Зорилт 7. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, метал хийц, машин үйлдвэрлэлийг хөгжүүлэх;** | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 7.1. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Засвар механикийн үйлдвэрийн хүчин чадлыг өргөтгөх, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх; | | | | | | | |
| 66 | 7.1.1. | Засвар механикийн үйлдвэрийн хүчин чадлыг өргөтгөх, бүтээгдэхүүний нэр төрлийг төрөлжүүлэхэд | Үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж, бүтээгдэхүүний нэр | Нэмэгдсэн хүчин чадлын хувь хэмжээ, | УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ | - | 2019-2022 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжлэг үзүүлэх | төрөл нэмэгдсэн байна. | Шинэ бүтээгдэхүүний тоо хэмжээ | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 7.2. Металл хийц, машин үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжин хөгжүүлэх; | | | | | | | |
| 67 | 7.2.1. | Метал хийцийн одоо байгаа үйлдвэрүүдийн хүчин чадал ашиглалтыг сайжруулах, шинээр үйлдвэр барихад дэмжлэг үзүүлэх; | Эрхзүйн орчин бүрдсэн байна. | Эрхзүйн орчныг сайжруулахаар боловсруулж, хэлэлцүүлж, батлуулсан саналын тоо | УУХҮЯ, АМГТГ | ТББ, мэргэжлийн холбоод | 2019-2023 |
| 68 | 7.2.2. | Ачааны автомашин, нийтийн тээвэр, ХАА-н машин механизмыг угсрах үйлдвэрлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх; | Эрхзүйн орчин бүрдсэн байна | Эрхзүйн орчныг сайжруулахаар боловсруулж, хэлэлцүүлж, батлуулсан саналын тоо | УУХҮЯ, АМГТГ | ТББ, мэргэжлийн холбоод | 2019-2020 |
| 69 | 7.2.3. | Машин угсрах болон автомашины эд анги үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүд болон шинээр үйлдвэр барихад дэмжлэг үзүүлэх; | Эрхзүйн орчин бүрдсэн байна | Эрхзүйн орчныг сайжруулахаар боловсруулж, хэлэлцүүлж, батлуулсан саналын тоо | УУХҮЯ, АМГТГ | ТББ, мэргэжлийн холбоод | 2019-2022 |
| 70 | 7.2.4. | Метал хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарт олон улсад мөрдөж байгаа эрх зүйн баримт бичигт нийцүүлэн үндэсний техникийн зохицуулалт, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх; | Эрхзүйн орчин бүрдсэн байна | Олон улсын стандартад нийцсэн дүрэм журмын тоо | УУХҮЯ, АМГТГ, Хувийн хэвшил | СХЗГ | 2019-2021 |
| 71 | 7.2.5. | Метал хийц, тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд чанар стандарт, тохирлын үнэлгээ, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах; | Үнэлгээ, дүгнэлт, чанарын хяналт хийсэн байна. | Үнэлгээ, дүгнэлт, чанарын хяналт хийгдсэн байгууллагын тоо | УУХҮЯ, АМГТГ | МХЕГ | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 7.3. Хүнд үйлдвэрлэлийн чиглэлийн үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, шинээр парк байгуулах асуудлыг судалж, эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор хөгжүүлэх; | | | | | | | |
| 72 | 7.3.1. | Дархан, Эрдэнэт, Баянговь нутаг ҮТП-ийн яамтай байгуулсан гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг харгалзан цаашдын үйл ажиллагааны талаар санал боловсруулах; | Санал боловсруулж, хэлэлцүүлсэн байна. | Боловсруулж, хэлэлцүүлсэн саналын тоо | УУХҮЯ, АМГТГ, ХХААХҮЯ | Хувийн хэвшил | 2019 |
| 73 | 7.3.2. | Багануур, Налайх дүүргийн ҮТП-ийг байгуулж хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх; | Санал боловсруулсан байна. | Боловсруулсан саналын тоо | УУХҮЯ, АМГТГ, ХХААХҮЯ, БХБЯ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| 74 | 7.3.3. | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлыг судлах судалгааны нэгжийг байгуулж ажиллуулах; | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ дэргэд судалгааны нэгж байгуулагдаж судалгаа хийсэн байна. | Боловсруулсан судалгааны тоо | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ТУЗ | - | 2019-2020 |
| 75 | 7.3.4. | Судалгаанд үндэслэн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах. | Санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулна. | Засгийн газрын хуралдааны шийдвэр | УУХҮЯ | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ | 2020 |
| Үйл ажиллагааны чиглэл 7.4. Хүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний сорилтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх; | | | | | | | |
| 76 | 7.4.1. | Хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний сорилтын лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх; | Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, зөвлөмж, санал хүргүүлсэн байна. | Боловсруулсан санал, зөвлөмжийн тоо | УУХҮЯ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 7.5. Хүнд үйлдвэрийг цогцоор хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай дэд бүтэц, тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээг бий болгох, эрчим хүчээр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлэх; | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 77 | 7.5.1. | Хүнд үйлдвэрийг цогцоор хөгжүүлэх дэд бүтэц, тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх; | Холбогдох судалгаа, мэдээллээр хангаж, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана. | Хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр | ЭХЯ, УУХҮЯ ЗТХЯ, ҮХГ, БХБЯ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| 78 | 7.5.2. | Хүнд үйлдвэрийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг эрчим хүчээр тасалдалгүй хангах үүднээс эрчим хүчний яамтай хамтран ажиллах; | Хамтран ажиллах санамж бичиг байгуулна. | Санамж бичиг | ЭХЯ, УУХҮЯ | Хувийн хэвшил | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 7.6. Хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа хөгжлийн ажлыг эрчимжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ төрлийг бий болгох, технологийн түвшинг сайжруулах, инновацийг нэвтрүүлэх; | | | | | | | |
| 79 | 7.6.1. | Олон улсын ижил төстэй үйлдвэрүүдтэй танилцах сургалт зохион байгуулах, судалгаа хөгжлийн ажлын талаар туршлага судлах; | Үйлдвэрүүд болон төслийн нэгжүүдтэй хамтран туршлага судлах сургалтыг зохион байгуулна. | Туршлага судлах сургалтын тоо | УУХҮЯ, АМГТГ, Төслийн нэгж | Хувийн хэвшил | 2020-2023 |
| 80 | 7.6.2. | Судалгаа хөгжлийн ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ төрлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх; | Санал боловсруулна. | Боловсруулж, танилцуулсан саналын тоо | УУХҮЯ, ҮХГ | АМГТГ, Төслийн нэгж | 2020-2023 |
| 81 | 7.6.3. | Хүнд үйлдвэрийн мэдээллийн санг бий болгож, шинэ технологи инновацийг нэвтрүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах. | Мэдээллийн сантай болно. | Мэдээллийн сан | УУХҮЯ, АМГТГ | Төслийн нэгж | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 7.7. Хүнд үйлдвэрийн томоохон төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр боловсруулж батлуулах; | | | | | | | |
| 82 | 7.7.1. | Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх; | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулсан байна. | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тоо | БОАЖЯ, УУХҮЯ | Хувийн хэвшил | 2021-2023 |
| 83 | 7.7.2. | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх; | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулсан байна. | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тоо | БОАЖЯ, УУХҮЯ | Хувийн хэвшил | 2021-2023 |
| 84 | 7.7.3. | Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх; | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулсан байна. | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тоо | БОАЖЯ, УУХҮЯ | Хувийн хэвшил | 2021-2023 |
| 85 | 7.7.4. | Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор барьж байгуулах төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх. | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулсан байна. | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тоо | БОАЖЯ, УУХҮЯ | Хувийн хэвшил | 2021-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 7.8. Хүнд үйлдвэрийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | | | | | | | |
| 86 | 7.8.1. | Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах чиглэлээр асуудал хариуцсан ажилтнуудад сургалт зохион байгуулах; | Сургалт зохион байгуулна. | Сургалтын тоо | УУХҮЯ | АМГТГ | 2020-2021 |
| 87 | 7.8.2. | Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах дүрмийг боловсруулж батлуулах. | Дүрэм боловсруулж, батлуулна. | Боловсруулж, батлуулсан дүрэм | УУХҮЯ | АМГТГ | 2020 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 8. Хүнд үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах;** | | | | | | | |
| Үйл ажиллагааны чиглэл 8.1. Шинээр баригдах болон одоо ажиллаж байгаа үйлдвэрүүдэд шаардлагатай мэргэжлийн инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэй ажиллах хүчний судалгааг гарган системтэй бэлтгэх арга хэмжээ авах; | | | | | | | |
| 88 | 8.1.1. | Үйлдвэрүүдэд шаардлагатай мэргэжлийн инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэй ажиллах хүчний судалгааг гаргаж, холбогдох яамдад захиалга өгөх ажлыг зохион байгуулах; | Жендэрийн мэдрэмжтэй судалгаа, зөвлөмжүүд боловсруулсан байна. | Жендэрийн мэдрэмжтэй судалгааны тоо | УУХҮЯ, БСШУСЯ | ХНХЯ, Төслийн нэгж, Мэргэжлийн холбоод | 2019-2021 |
| Үйл ажиллагааны чиглэл 8.2. Инженер, техникийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиуд, политехникийн коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж, мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэшүүлэх, дадлагажуулах; | | | | | | | |
| 89 | 8.2.1. | Инженер, техникийн ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах; | Шаардлагатай сургалтыг зохион байгуулсан байна. | Жендэрийн тэнцвэрийг хангасан сургалтын тоо | УУХҮЯ, холбогдох их, дээд сургууль | Мэргэжлийн холбоод, Үйлдвэрийн газрууд | 2019-2023 |
| 90 | 8.2.2. | Мэргэшсэн, зөвлөх инженерийн сургалтыг зохион байгуулах; | Шаардлагатай сургалтыг зохион байгуулсан байна. | Жендэрийн тэнцвэрийг хангасан сургалтын тоо | УУХҮЯ, ШУТИС | Мэргэжлийн холбоод, Үйлдвэрийн газрууд | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 8.3. Ажлын байран дахь болон зайны сургалтаар мэргэжилтэй ажилчдыг сургаж, бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх; | | | | | | | |
| 91 | 8.3.1. | Үйлдвэрийн ажилчдыг бусад ижил төстэй үйлдвэртэй танилцуулах, богино хугацаагаар дагалдаж ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээг авах; | Дадлагажуулах сургалт зохион байгуулсан байна. | Жендэрийн тэнцвэрийг хангасан сургалтын тоо | УУХҮЯ | Мэргэжлийн холбоод, Үйлдвэрийн газрууд | 2019-2023 |
| 92 | 8.3.2. | Мэргэжлийн ажилчдыг зайны сургалт, мэргэжлийн зэрэг олгох сургалтанд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авах; | Зайны болон мэргэжлийн зэрэг олгох сургалт зохион байгуулсан байна. | Жендэрийн тэнцвэртэй Зайны болон мэргэжлийн зэрэг олгох сургалтын тоо | УУХҮЯ, БСШУСЯ, ХНХЯ | Мэргэжлийн холбоод, Үйлдвэрийн газрууд | 2019-2023 |
| Үйл ажиллагааны чиглэл 8.4. Боловсруулах үйлдвэрийн нарийн мэргэжлээр өндөр хөгжсөн оронд давтан сургах, туршлага судлуулах, чадавхжуулах; | | | | | | | |
| 93 | 8.4.1. | Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийн мэргэжлийн инженерийг Энэтхэг улсад үе шаттайгаар бэлтгэх; | Энэтхэг улсад инженерүүдийг нарийн мэргэжлийн сургалтад хамруулсан байна. | Сургалтад хамрагдсан инженерийн тоо | УУХҮЯ, | Мэргэжлийн холбоод, Үйлдвэрийн газрууд | 2019-2023 |
| 94 | 8.4.2. | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нарийн мэргэжлийн инженерийг өндөр хөгжилтэй оронд үе шаттайгаар сургах, давтан сургах, туршлага судлуулах; | Инженерүүдийг нарийн мэргэжлийн сургалтад хамруулсан байна. | Сургалтад хамрагдсан инженерийн тоо | УУХҮЯ | Мэргэжлийн холбоод, Үйлдвэрийн газрууд | 2019-2023 |
| 95 | 8.4.3. | Нүүрсийг гүн боловсруулах, химийн үйлдвэрийн нарийн мэргэжлийн инженерийг БНХАУ-д үе шаттайгаар сургах, давтан сургах, туршлага судлуулах; | Хятад улсад инженерүүдийг нарийн мэргэжлийн сургалтад хамруулсан байх | Сургалтад хамрагдсан инженерийн тоо | УУХҮЯ | Мэргэжлийн холбоод, Үйлдвэрийн газрууд | 2019-2023 |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ